



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 35 06, Факс: (976-11) 31 81 69,
Цахим хуудас: www.mmhi.gov.mn

2023.02.10 № 03/451


танай _____-ны № _____-г

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНД

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багц болон харьяа байгууллагуудын 2022 оны худалдан авах ажиллагааны биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.

Үнэлгээний тайлантай танилцаж, өгөгдсөн санал зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 2-хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БЯМБАДАГВА

1508 05 0478

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦ БОЛОН ХАРЪЯА
БАЙГУУЛЛАГУУДЫН 2022 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

2022 оны жилийн эцсийн байдлаар

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах ажиллагаа 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,844,640.29 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төрлийн худалдан авалтад 1,928,600.57 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 83,960.28 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 100 оноо бүхий шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд **98,7** оноогоор үнэлэгдэв.

1.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагаа хийгдээгүй ба зайлшгүй засвар хийх шаардлага үүссэн тул урсгал зардлаас 158,235.6 мянган төгрөгийн зохицуулалт хийсэн нь төлөвлөгөөг хэтрүүлэхэд нөлөөлсөн байна.

1.3 Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 ажлыг 5 багцад хуваан сонгон шалгаруулалт зарласан, мөн чанарын үнэлгээний аргаар 4, хосолмол үнэлгээний аргаар 1, харьцуулалтын аргаар 1 шалгаруулалт зарлаж бүх тендерийг хүчинтэй байх хугацаанд нь үнэлсэн байна.

1.4 Гэрээ шууд байгуулах аргаар 12 төрлийн худалдан авалт хийсэн ба бүх тендерийг хүчинтэй байх хугацаанд нь үнэлсэн байна.

1.5 Худалдан авах ажиллагааны явцад ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

1.6 Тайланд худалдан авсан барааны мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэрийг бүрэн тусгасан. Харин гэрээний хэрэгжилтийн талаар тайлбар ирүүлээгүй байна.

Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим систем ашигласан талаар

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системийг 2022 онд бүх худалдан авалтад ашигласан байна.

Гурав. Харъяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар

3.1 АМГТГ-ын 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **92,68** хувиар, УГА-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **92.0** хувиар, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **95.0** хувиар үнэлэгдлээ.

Дөрөв. Дүгнэлт


Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны багцын худалдан авах ажиллагааны тайланг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу үнэлэхэд худалдан авах ажиллагаа **94,5** хувийн биелэлттэй “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдлээ.

Тав. Санал зөвлөмж

1. Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний талаар тайлбар, үндэслэлийг тоо баримттайгаар тайландаа тодорхой тусгаж хэвших;
2. Гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, гэрээнд заасан хугацаанд бараа, ажил үйлчилгээг хүлээн авах ажлыг зохион байгуулах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох;
3. Ажлын биелэлтийг гаргахдаа үнийн дүн болон хувиар илэрхийлэн тайлагнаж хэвших;
4. Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулж, хийгдэх боломжгүй худалдан авалт төлөвлөхгүй байх;

Тайлбар: Тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-д заасан загвараар боловсруулав.

Хянасан: ХШУДАГ-ын дарга



Т.Баасанпүрэв

Тайлан бичсэн:

ХШУДАГ-ын ахлах шинжээч



Х.Цэнд-Аюуш /2023.02.13/

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР